



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 110

Шивээговь сум

Монгол Улсын иргэнд газар өмчлөх  
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжүүлсэнтэй холбогдуулан иргэн Боржгин овогтой Жавзандулам /ЕЙ37041704/ сумын Засаг даргын 2005 оны 04 дүгээр 28-ны өдрийн 40.А дугаар захирамжаар 2 дугаар баг, 22 дугаар зөвлөгт байрлах 900 м<sup>2</sup> газар өмчилж авсан нь мэргэжлийн байгууллагаар суурин кадастрын зургийг хийхэд талбайн хэмжээ, хаяг өөрчлөгдсөн тул Боржгин овогт Гомбын Жавзандуламд 2 дугаар баг, Рашаант-1 гудамжны 113 тоотод байрлах 2500 м<sup>2</sup> талбайтай, 3500000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийн үнэ бүхий газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлсүгэй.

2.Өмчилж авсан тухайн газраа улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн (Гомбын Жавзандулам)-д үүрэг болгосугай.

3.Газар өмчлөлийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 40.А дугаар захирамжийн хавсралтын 7 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ



42123 : 63